



Цахим шууданд

# ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2022 ОНЫ МАРШ, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН АВАРГУУД ТОДОРЛОО

**Түрүүч нь эхний нүүрт**

Б а и н г ы н бүрэлдэхүүний салааны тэргүүн байрт хурандаа Д.Шинэбаяр захирагч, ахлах дэслэгч С.Цэрэнням салааны захирагчтай Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн баг (1:08:30.72), дэд байрт дэд хурандаа А . Г ү р б а д а м захирагч, ахлах дэслэгч Ц.Лхагвасүрэн салааны захирагчтай Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн баг (1:12:41.87), гутгаар байрт дэд хурандаа Б.Олзбаяр захирагч, дэслэгч Т.Тэмүүлэн салааны захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн баг тамирчид (1:14:54.67) шалгарч, шагналаа гардан авав. Спортын талбарт хүчтэй өрсөлдөгчид хэдий ч эх орон, тусгаар тогтнол, ард түмнийхээ төлөө зүтгэхэд гар нийлсэн эрхэм хамтрагчдад дараа жилийн уралдаан даанч хол байна гэлцсээр тарлаа.



## ЕРӨНХИЙ ЦЭРГИЙНХНИЙ МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫГ ШАЛГАСАН ТАКТИКИЙН ОЛИМПИАД ЭХЭЛЛЭЭ



Жил бүрийн 5 дугаар сарын 14-ний өдөр тохиодог "Ерөнхий цэргийн өдөр"-ийг угтан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас залуу офицер, ахлагч нарыг мэргэжлээрээ бахархаж, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэхэд нь чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байна. Үүний нэг нь "Монгол Улсын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн нэрэмжит тактикийн олимпиад-2022" уралдаан юм. Найм дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа энэхүү уралдаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн рот, батарейн захирагч болон түүнтэй дүйцэх албан тушаалтнууд оролцож байгаа бөгөөд Хуурай замын цэргийн командлал, ҮБХИС-ийн Ерөнхий цэргийн тэнхим, "Ерөнхий цэрэг ассоциаци" төрийн бус байгууллага, ЦИС-ийн 1972 оны төсөгчид хамтран зохион байгуулж байгаа юм. Тэмцээний нээлтийн ёслол 5 дугаар сарын 10-ны энэ өдөр болж, ХЗЦК-ын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн дарга,

хурандаа Т.Тогмиддүүмий, ҮБХИС-ийн Ерөнхий цэргийн тэнхимийн дарга, дэд хурандаа П.Отгонтулга, "Ерөнхий цэрэг ассоциаци" ТББ-ын тэргүүн, бэлтгэл хурандаа Л.Ганбаатар болон ЦИС-ийн 1972 оны анхны дээд мэргэжилтэй Ерөнхий цэргийн офицеруудын төлөөлөл бэлтгэл хурандаа Ш.Мөнхсайхан, Ү.Зөвлхам, Ц.Пүрэвдорж нарын зочид оролцон, уралдаанд оролцогчдод мэргэжлээрээ бахархаж, мэдлэг, ур чадвараараа тэргүүлж, хариуцлага, ёс зүйтэй байдлаараа бусдаасаа илүүрхэж явахыг захилаа. Уламжлалт болсон тактикийн олимпиад нь сүүлийн хоёр жил "Ковид-19" цар тахлын улмаас тасалдаж,

ерөнхий цэргийнхэнд хүлээлт үүсгэсэн байсан талаар зохион байгуулагчид онцолж байв. Олимпиад онол, дадлагаар зохион байгуулагдах ба дүн нь маргааш буюу 5 дугаар сарын 11-ний өдөр гарна. Ташрамд дурдахад, Монгол Ардын Хувьсгалт цэргийн мотоциудлагын батальон 1956 оны 5 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсанаар орчин цагийн Ерөнхий цэргийн түүх эхэлсэн бөгөөд хожмоо ерөнхий цэргийн офицеруудаас гаргасан санал, санаачилгад тулгуурлан Батлан хамгаалахын сайдын 2007 оны 122 дугаар тушаалаар энэхүү өдрийг "Ерөнхий цэргийн өдөр" болгон баталгаажуулсан билээ.



## "ҮНЭ ЦЭН" МЮЗИКЛИЙН УУЛЗАЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛ ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА



Энэ онд тохиож буй Монгол улс энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ой, ЦДБЭЧ-ын түүхт 90 жилийн ойд зориулан бүтээж буй "ҮНЭ ЦЭН" мюзикл тун удахгүй үзэгчдийн хүртээл болох гэж байна.

Тус мюзиклийг бүтээж буй баг, хамт олон энэ өдөр Монголын энхийг сахиулагчдын бахархал, үлгэр жишээ, түүчээ нь болж яваа хүндэтгэлийн эзэн хошууч Г.Аззаяатай бүтээлийн

судалгааны уулзалтыг зохион байгуулсан юм. Тэрээр Монгол цэргүүдийн томоохон шалгууруудын нэг болох энхийг сахиулах ажиллагааны тухай "ҮНЭ ЦЭН" мюзикл бүтэх гэж буйд туйлын талархалтай байгаа илэрхийлж, үүрэг гүйцэтгэсэн газар орон, орон орны энхийг сахиулагч цэргүүдийн онцлог, Монгол цэргүүдийн авхаалж самбаа, цэргийн андуудын нөхөрлөл, үнэ цэнийн тухай өөрийн мэдлэг туршлага, бодлоосоо хуваалцахын

зэрэгцээ хамт үүрэг гүйцэтгэсэн дайчин нөхөд, өөрийн шилдэг хамтрагч бэлтгэл ахмад Ш.Самбуу-Ёндогийнхоо эр зоригийн тухай олон зүйлсийг дурсан ярьсан юм.

Мөн хошууч Г.Аззаяа "ҮНЭ ЦЭН" мюзикл бүтэхэд бүхий л сэтгэлээрээ дэмжиж байгаагаа илэрхийлж, тус бүтээл бол Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эр зориг тэсвэр хатуужлыг эгшиг дуу, эвийн сэтгэлээр харуулж чадсан "ҮНЭ ЦЭН"-тэй урт настай бүтээл болно гэдэгт итгэж буйгаа мюзикл бүтээж буй баг, хамт олонд тодотгон хэлсэн юм.

Өдгөө 20 жилийн арвин түүхээ бичиж буй Монголын олон мянган дайчин эрсийн эр зориг, мэргэжлийн ур чадварыг сорьж, эх дэлхийн энхжинг дархлаа их үйлсийг бахдан харуулах тус мюзикл чадварлаг баг, хамт олон, авьяаслаг уран бүтээлчдийн нөр их хөдөлмөр зүтгэлээр тун удахгүй үзэгч таныг сонорыг мялаах болно.

### УРИАЛГА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НИЙТ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН ТА БҮХНИЙГ МӨРДӨС НЭГТ НӨХРИЙН БЯЦХАН ОХИНД ЭРҮҮЛ АМЬДРАЛЫГ БЭЛЭГЛЭХ "САЙН ҮЙЛСИЙН АЯН"-Д УРИАЛЖ БАЙНА





БНСУ-д яаралтай хагалгаа хийлгэх У.Маргад охины эмчилгээнд 300-450 сая төгрөг шаардлагатай болсон тул сайжир сэтгэлт мөрдөст нэгт эрхэм нөхөд минь бидэнд тусална уу

Бяцхан бие нь даамгүй тархины үрэвсэл хэмээх хүнд өвчнөөр шаналж байгаа гуравхан настай У.Маргад охинд олон түмний минь сэтгэлийн гал, итгэлийн хүч юу юунаас илүү хэрэгтэй боллоо.

ХАНДИВЫН ДАНС

Данс эзэмшигч:  
Эж- Сэргэлэн Ганзаяа  
Харилцах утас:  
С.Ганзаяа 88376062

ХААН БАНК: 5073035840

ГОЛОМТ БАНК: 4305125348